

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1.Орон нутгийн хөгжлийн сан /цаашид ОНХС гэх/-г төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд энэ журмыг баримтална.
- 1.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Малын тоо толгойн албан татварын тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг үндэслэнэ.
- 1.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 1.4.ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тооцох, батлах

- 2.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /цаашид ОНХНС гэх/-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал", Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал"-д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр тооцсон суурь тооцооллыг орон нутгийн төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.
- 2.2.Жил бүрийн төсвийн төсөлд ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг аймаг, нийслэл тус бүрээр, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгож буй урамшуулал, дэмжлэгийг хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд сум, дүүрэг тус бүрээр тусган батлуулна.
- 2.3.Тухайн жилийн Монгол Улсын төсвийг Улсын Их Хурлаар баталснаас хойш ажлын 5 хоногийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн систем (цаашид УМС гэх)-ээр дамжуулан ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүнг мэдээлнэ.
- 2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасны дагуу батлагдсан аймаг, нийслэлийн ОНХС-ийн орлогын шилжүүлэгт үндэслэн сумдын ОНХС-ийн суурь тооцооллыг тооцож тухайн жилийн төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэн баталснаас хойш ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.
- 2.5.Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь сум, дүүргийн ОНХС-д хуваарилах орлогын шилжүүлгийн дүнг тооцохдоо энэ журмын 2.4-т заасан суурь тооцооллын дүн, ОНХС-аас санхүүжих суурь зардал болон Төсвийн тухай 60.2.4, 60.2.5, 60.2.8-д заасан бусад эх үүсвэрийн хамт тухайн жилийн аймаг, нийслэлийн төсвийн төсөлд энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (цаашид ИТХ гэх)-д өргөн мэдүүлнэ.
- 2.6.Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу ОНХНС-аас хуваарилсан хөрөнгөөс аймаг, нийслэлийн ОНХС-д үлдэх хөрөнгө болон бусад эх үүсвэрийг энэ журмын 9 дүгээр хавсралтад тусгана.
- 2.7.Сум, дүүргийн ИТХ малын тоо толгойн албан татварын тухайн жилийн орлогыг тооцон баталж, баталснаас хойш ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. Аймаг, нийслэл Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 2.8.Энэ журмын 2.5, 2.6 болон 2.7-д заасан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална.
- 2.9.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн төсөвт орсон өөрчлөлтийг орон нутгийн төсвийн тодотголын төсөлд тусган Төсвийн тухай хуульд заасны дагуу боловсруулж батлуулна.

Гурав. ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг

- 3.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэг:
- 3.1.1. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмын дагуу тооцоолон боловсруулах;
- 3.1.2.ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн тооцооллыг тооцоолон боловсруулах;
- 3.1.3.ОНХС-ийн орлогын шилжүүлгийг тус санг бүрдүүлдэг эх үүсвэрүүдийн орлогын гүйцэтгэлд үндэслэн шилжүүлэх;
- 3.1.4.ОНХС-ийн гүйцэтгэлд хяналт тавих, ОНХС-ийн УМС-ийг хариуцаж, тайлан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, журмыг боловсруулж сайжруулах.
- 3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг:
- 3.2.1.Ажлын хэсгийн боловсруулсан тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг санал тус бүрээр хэлэлцэн батлах, нийтэд мэдээлэх;
- 3.2.2.Тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.2.3.Тухайн шатны ИТХ-ын тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг ИТХ-аас ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан УМС-д оруулна.
- 3.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг:
- 3.3.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;
- 3.3.2.ОНХНС-аас олгох ОНХС-ийн шилжүүлгийг хууль, журамд заасны дагуу үнэн зөв тооцоолж сум, дүүргийн ОНХС-д хуулийн хугацаанд шилжүүлэх;
- 3.3.3.ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.3.4.ИТХ-аар баталсан төсвийг хуулийн хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 3.3.5.Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх цаашид авах арга хэмжээг зохион байгуулах;
- 3.3.6.Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлнэ.
- 3.3.7.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
- 3.3.8.ОНХС-ийн УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах;
- 3.3.9. ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх.
- 3.4. Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг:
- 3.4.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах;
- 3.4.2.ИТХ-аар баталсан төсвийг хуулийн хугацаанд аймаг, нийслэлийн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн нэгжид хүргүүлэх;
- 3.4.3.Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 3.4.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих;
- 3.4.5.ОНХС-ийн УМС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах;

3.4.6.ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх.

3.5. Баг, хорооны Засаг даргын чиг үүрэг:

3.5.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулах;

3.5.2.ОНХС-ийн УМС-ийн төлөвлөлт цэсэд ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулах;

3.5.3.Иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын урьдчилсан жагсаалтыг бэлтгэж иргэдийн Нийтийн Хурал/цаашид ИНХ гэх/-д хүргүүлэх;

3.5.4.ОНХС-ийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх.

Дөрөв. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг, үндсэн нөхцөл

4.1.Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.Үүнд:

4.1.1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

4.1.2.Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх;

4.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;

4.1.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;

4.1.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;

4.1.6.Аймаг, нийслэлийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх;

4.1.7.ОНХС-ийн хөрөнгөөр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах.

4.2. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд:

4.2.1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;

4.2.2.Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;

4.2.3.Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;

4.2.4.Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;

4.2.5.Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;

4.2.6.Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх;

4.2.7.Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;

4.2.8.Ажлын байр бий болгох.

4.3. Сум, дүүргийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.Үүнд:

4.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

4.3.2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

4.3.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах;

4.3.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;

4.3.6.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдан ажлын гүйцэтгэл нь баталгаажсан боловч тухайн онд санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрийг нэгдсэн жагсаалтад оруулах;

4.3.7.Сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах.

4.3.8.ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр бий болох хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний өмчлөл, цаашдын ашиглалтын урсгал зардал, шинээр бий болох орон тоог орон нутаг өөрөө хариуцах;

4.4. Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.Үүнд:

4.4.1.Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;

4.4.2.Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;

4.4.3.Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;

4.4.4.Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;

4.4.5.Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;

4.4.6.Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;

4.4.7.Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;

4.4.8.Ажлын байр бий болгох;

4.4.9.Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.

4.5.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. Үүнд:

4.5.1.Бэлчээрийн менежментийг сайжруулах;

4.5.2.Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/

4.5.3.Малын эрүүл мэндийг хамгаалах;

4.5.4.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

4.5.5.Малын чанарыг сайжруулах;

4.5.6.Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;

4.5.7.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;

4.5.8.Малын тэжээлийн ургамал тариалах;

4.5.9.Тэжээлийн нөөц бүрдүүлэх;

4.5.10.Байгаль орчныг хамгаалах;

4.5.11.Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;

4.5.12.Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

4.6.ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй:

4.6.1.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор;

4.6.2.Энэхүү журамд заасан болон Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүрэгт хамаарах;

4.6.3. Төсвийн тухай хуулийн 58.1.8, 58.1.12, 58.2.11, 58.2.12, 58.2.15, 58.3.4, 58.4.3, 58.4.4, 58.4.9, 58.4.10-т [1] заасан төрлийн үйлчилгээний зардал.

4.7. Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй:

4.7.1.Улс төрийн нам, эвсэл, түүний харьяа аливаа төрлийн байгууллага, төрийн бус байгууллагын зарлага;

4.7.2.Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал;

4.7.3.Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;

4.7.4.Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа, батлан даалт гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг а вах;

4.7.5.Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ;

4.7.6.Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал.

Тав. Баг, хорооны түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

5.1.Баг, хорооны Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн төсвийн жилийн аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ, мэдээллийн хэрэгслээр дамжуулан жил бүрийн 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна.

5.2.Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна. Үүнд:

5.2.1.санал асуулгын хуудас;

5.2.2.бүлгийн ярилцлага /орон нутгийн иргэд өөрсдөд тулгамдаж буй асуудлаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж сайн дурын үндсэн дээр нэгдсэн бүлгийн зохион байгуулалт/;

5.2.3.цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр.

5.3.Энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг баг, хорооны иргэдэд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.

5.4.Энэ журмын 5.2.2-т заасан хэлбэрээр санал авах тохиолдолд хорооны хувьд 50-аас доошгүй /дүүргийн төвөөс алслагдсан хорооны хувьд 30-аас доошгүй/, багийн хувьд 30-аас доошгүй /сумын төвөөс алслагдсан багийн хувьд 20-оос доошгүй/ иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлагыг бүлэг тус бүр зохион байгуулах ба ярилцлагын үеэр иргэдээс авсан саналыг энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан хэлэлцүүлгийн тэмдэглэлд тусган хэлэлцүүлгт оролцсон иргэдийн гарын үсгээр баталгаажуулна.

5.5.Энэ журмын 5.2.3-т заасан арга хэлбэрээр санал авах тохиолдолд 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудас, гар утасны программ ашиглан санал өгч буй иргэнийг баталгаажуулах боломжтойгоор ОНХС-ийн саналыг хүлээн авах бөгөөд саналыг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэн баталгаажуулна.

5.6.Энэ журмын 5.2-т заасан хэлбэрээр иргэдээс санал авах ажлыг жил бүр зохион байгуулна.

5.7.Баг, хорооны Засаг дарга энэ журмын 5.6-д заасны дагуу иргэдээс авсан саналыг нэгтгэн урьдчилсан жагсаалтыг бэлтгэхдээ энэ журмын 5 дугаар хавсралтад заасан маягт ад багтсан үзүүлэлтийг ирсэн санал бүрийн хувьд боловсруулах ба энэ журмын 5.1-д заасан танилцуулгад үндэслэн мэдээлэл бэлтгэж, баг, хорооны ИНХ-д оруулж хэлэлцүүлнэ.

5.8.Баг, хорооны ИНХ-ын дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хуралдааныг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 6 дугаар сард багтаан зохион байгуулна.

5.9.Баг, хорооны ИНХ-ын дарга хурлын ирцийг бүртгэн оролцогчдоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу хөтөлж, гарын үсгээр баталгаажуулна.

5.10.Баг, хорооны Засаг дарга дараагийн төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх энэ журмын 5.7-д заасан урьдчилсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал тус бүрийг ИНХ-д танилцуулна.

5.11.Баг, хорооны Засаг дарга ИНХ-д ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар тайлагнахдаа энэ журмын 9.4, 9.5-д заасан этгээдийн хийсэн ажлын тайлан, тэмдэглэл, гаргасан дүгнэлт, зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх ажлын санал, акт, албан шаардлагыг сонсгож болно.

5.12.Баг, хорооны ИНХ-ын дарга энэ журмын 5.10-т заасны дагуу танилцуулсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал болон тухайн хурлын үеэр дэвшүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал тус бүрийг дэмжиж буй эсэхийг ил тод санал хурааж шийдвэрлэнэ.

5.13.Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг энэ журмын 5.12-т заасан санал өгсөн иргэдийн тоог баг, хорооны сонгуулийн насны иргэдийн нийт тоонд харьцуулсан харьцаагаар эрэмбэлсэн тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг ИНХ-ын тогтоолоор батална.

5.14.Баг, хорооны ИНХ-ын дарга энэ журмын 5.13-т заасан жагсаалтыг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан баг, хорооны ИНХ-ын тэмдэглэлд тусгана.

5.15.Баг, хорооны Засаг дарга энэ журмын 5.13-т заасан тогтоол болон энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийн танилцуулгыг энэ журмын 5.8-д заасан хугацаанд багтаан сум, дүүргийн Засаг даргад албан бичгээр хүргүүлнэ.

Зургаа. Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх

6.1.Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулна.

6.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь орон нутгийн хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан, төрийн сангийн мэргэжилтэн, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл болон бусад мэргэжилтнүүдийг багтаасан 7-оос доошгүй гишүүнтэй байна.

6.3.Ажлын хэсэг нь энэ журмын 5.13-т заасан баг, хорооны ИНХ-аас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгтгэн эрэмбэлж, нэгдсэн жагсаалтыг жил бүрийн 7 дугаар сард багтаан боловсруулна.

6.4.Ажлын хэсэг нь баг, хороодоос ирсэн саналыг нэгтгэж эрэмбэлэхдээ дараах үзүүлэлтүүдийг харгалзан зөвлөмж, дүгнэлт гарган сум, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. Үүнд:

6.4.1.Баг, хороодоос ирүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь баг, хорооны иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх;

6.4.2.Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх;

6.4.3.Энэ журмын 4.6-д заасны дагуу хасагдах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ байгаа эсэх;

6.4.4.Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төслийн төсөвт өртгийн харьцаа.

6.5.Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

6.6.Сум, дүүргийн Засаг дарга нь баг, хорооны ИНХ-ын баталсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй бол тухайн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

6.7.Сум, дүүргийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг тухайн шатны ИТХ-д төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

6.8.Сум, дүүргийн ИТХ нь сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

6.9.Сум, дүүргийн Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн баг, хорооны Засаг даргаар дамжуулан иргэдэд тухайн жилд нь багтааж мэдээлнэ.

6.10.Сум, дүүргийн Засаг дарга нь ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэхээр иргэд, малчдаас гаргасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг журмын 4.5-д заасан чиг үүргийн дагуу сум, дүүргийн бэлчээр ашиглалт, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй тус тус уялдуулан боловсруулж ИТХ-д танилцуулж батлуулна.

Долоо. Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн төлөвлөлт

7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

7.2.Аймаг, нийслэл нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсгээр хянаж эрэмбэлүүлнэ.

7.3.Ажлын хэсэг аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг сум, дүүргээс ирүүлсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад үндэслэн дараах үзүүлэлтүүдийг харгалзан үзэж боловсруулна. Үүнд:

7.3.1.Тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

7.3.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ;

7.3.3.Өмнөх төсвийн жилд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ;

7.3.4.Хөрөнгө оруулалтын урьдчилан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан харьцаа.

7.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

7.5.Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

7.6.Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

7.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.

7.8.Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн саналыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцэн энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу батална.

Найм. ОНХС-ийн хэрэгжилт

8.1.ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

8.2.ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг дагаж мөрдөнө.

8.3.Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймаг, нийслэлийн түвшинд, сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг сум, дүүргийн түвшинд зохион байгуулна.

8.4.Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.2 дахь хэсэг болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан "Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам"-ын дагуу зохион байгуулж болно.

8.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.

8.6.Энэхүү журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн төрийн сан дахь данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна.

8.7.ОНХС-ийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т заасны дагуу төсвөөс санхүүжилт олгохгүй байх үндэслэл болно.

8.8.ОНХС-ийн болон сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх малын тоо толгойн албан татварын орлогын төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

8.9.ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй.

Ес. ОНХС-ийн тайлагналт, бүртгэл

9.1.Дүүргийн Төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтын дагуу аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана.

9.2.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

9.3.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

9.4.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

9.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ.

9.6.Энэ журмын 9.5-д заасны дагуу хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хүлээнэ.

9.7.Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.

9.8.Энэ журмын 9.4, 9.5-д заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.

9.9.Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгжид ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 9.9.1.ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;
- 9.9.2.ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;
- 9.9.3.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;
- 9.9.4.Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн гэрэл зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;
- 9.9.5.Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;
- 9.9.6.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;
- 9.9.7.Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга.

9.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан нэгж нь тайланд дүн шинжилгээ хийж, ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого боловсруулна.

9.11.ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ.

9.12.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

Арав. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн систем

10.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ОНХС-ийн УМС-ийг хариуцаж ажиллана.

- 10.1.1.УМС-ийн аюулгүй байдал, өгөгдлийн сан, систем байршиж буй сервер, сүлжээ, мэдээлэл татах, вэб сервисийн хэвийн ажиллагааг төрийн захиргаа удирдлагын асуудал хариуцсан нэгж;
- 10.1.2.УМС-ийн дотоод үйл ажиллагаа болон систем ашиглалт, заавар зөвлөгөө, системийн хэрэглэгчдийн бүртгэл, өөрчлөлтийг төсвийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж.

10.2.ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, хяналт, бүртгэлд УМС ашиглах ба дараах байдлаар бүртгэнэ. Үүнд:

- 10.2.1.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.2.ОНХС-аас аймаг, нийслэлд шилжүүлэх орлогын шилжүүлгийн сар, улирлын батлагдсан хуваарийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.3.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс нь орон нутгийн төсвийн батлагдсан сар, улирлын хуваарьтай нийцүүлэн ОНХС-ийн сум, дүүргээр хуваарилан баталсан сар, улирлын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна;
- 10.2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС хариуцсан нэгж нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийг Төв төрийн сангийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарсны дараа ажлын 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн ОНХС-ийн дансанд шилжүүлж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ;
- 10.2.5.Аймаг, нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хуваарилагдан ирсэн орлогын шилжүүлгийг ажлын 2 өдөрт багтаан батлагдсан хуваарийн дагуу сум, дүүргээг хуваарилж, ОНХС-ийн УМС-д бүртгэнэ.

10.3.Тухайн орон нутгийн төрийн сангийн төлбөр тооцоо, зарлага хариуцсан мэргэжилтэн нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ ОНХС-ийн УМС-ийг дараах байдлаар ашиглана.

- 10.3.1.Баг, хорооны Засаг дарга, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн УМС-ийн төлөвлөлт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүрийн 6 дугаар сард багтаан бүрэн оруулж, өөрийн ажлын хүрээнд шаардлагатай мэдээллийг гарган авч ашиглана;
- 10.3.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ;
- 10.3.3.ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй;
- 10.3.4.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймаг, нийслэлийн, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь сум, дүүргийн ОНХС-ийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилттэй холбоотой хийгдсэн аудит, хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлага болон бусад мэдээллийг мэдээллийн хэрэгслээр дамжуулан хагас, бүтэн жилээр мэдээнэ.

Арван нэг.Хариуцлага

11.1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.

11.2.ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1 дүгээр хавсралт

ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ МАЯГТ		Саналын хуудасны бүртгэлийн №.....	
*18-аас дээш насны иргэн бөглөнө.	Хүйс:	эр	эм
Жич: Та нэгдмэл сонирхолтой иргэдтэй бүлэг болж саналаа нэгтгэн баталгаажуулсан тохиолдолд таны/ танай бүлгийн санал олонхын саналаар			

Аймаг/Нийслэл	Сум/Дүүрэг	Баг/Хороо		
Гэрийн хаяг:хаягт оршин сууховогтой...../регистер №...../ Та "Орон нутгийн хөгжлийн сан" /цаашид ОНХС гэх/-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ/цаашид төсөл гэх/-ий талаар саналаа өгнө үү.				
1. Сум/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан сум/дүүргийн ЗДТГ-аас санал болгож буй дараах төслүүдийг дэмжиж байгаа эсэхээ хүснэгтэд тэмдэглэнэ үү.				
Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл хэрэгжих байршил, хүчин чадал	Дэмжиж байгаа бол ТИЙМ	Дэмжихгүй байгаа бол ҮГҮЙ	
1.1 /ЗДТГ-аас санал болгож буй төсөл/				
1.2.....				
1.3.....				
Нэмэлт тайлбар:				
2. Та амьдарч буй сум/дүүрэг, баг/хороогоо хөгжүүлэх төслийн саналаа бичнэ үү.				
Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл хэрэгжих байршил, хүчин чадал	Үр ашиг хүртэгчдийн тоо		
2.1 /Иргэний санал – 1/				
2.2 /Иргэний санал – 2/				
2.3.....				
2.4.....				
3. Та Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх төслийн саналаа бичнэ үү.				
Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл хэрэгжих байршил, хүчин чадал	Үр ашиг хүртэгчдийн тоо		
3.1 /Санал-1/				
3.2 /Санал-2/				
3.3.....				
3.4.....				
..... онысарын..... өдөр				
Иргэнд үлдэх хэсэг : Саналын хуудасны бүртгэлийн №.....				
Саналын хуудас хүлээн авсан хүний овог, нэр	Хүлээлгэн өгсөн Баг/хорооны Засаг даргын овог, нэр	Огноо		
.....		оны.....сарын.....өдөр		
Тэмдэглэл: Таны болон танай баг/хорооны иргэдийн гаргасан саналыг эрэмбэлж нэгтгэноны сарын..... -ны өдөр баг/хорооны ИНХ-аар хэлэлцэж батлах тул ИРГЭН ТА хуралдаа идэвхтэй оролцоно уу.				
Д/д	Төслийн санал	Санал өгсөн иргэдийн тоо	Санал өгсөн иргэдийн тоог баг/дүүргийн сонгуулийн насны нийт хүн амын тоонд харьцуулсан харьцаа	
1				
2				
3				
4				
...				

дэмжигдэн дээгүүр эрэмбэлэгдэх давуу талтай.

2 дугаар хавсралт

Санал асуулгын хуудсаар авсан төслийн саналын жагсаалт

.....аймаг/нийслэлийн..... сум/дүүргийн.....баг/хорооны 20... оны "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн санал асуулгын хуудсаар авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт

Нийт өрхийн тоо..... Баг/хорооны хүн амын тоо Баг/хорооны сонгуулийн насны хүн амын тоо..... Санал асуулгын хуудсаар санал өгсөн иргэний тоо.....

Нээлттэй хэлэлцүүлэг, бүлгийн ярилцлагын маягт

.....аймаг/нийслэлийн..... сум/дүүргийн.....баг/хорооны бүлгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр онд хэрэгжүүлэх төслийн саналын жагсаалт:

Санал асуулгын хэлбэр/дугаарыг тэмдэглэнэ/

1. Хэлэлцүүлэг
2. Бүлгийн ярилцлага

Оролцсон хүний тоо:

	Хэлэлцсэн төслийн нэр	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо
1		
2		
3		
4		
...		

Санал асуулга эхэлсэн хугацаа

Санал асуулга дуусгавар болсон хугацаа

Санал асуулгад оролцогчдын жагсаалтыг хавсаргана.

Танилцаж хүлээн авсан Засаг даргын гарын үсэг:/...../

Техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэрээр авсан

төслийн саналын жагсаалт

Санал өгсөн иргэдийн нийт тоо:

Үүнээс: Цахим шуудангаар:

Цахим хуудсаар:

Мессежээр:

Гар утасны программаар:

	Төслийн санал	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо
1		
2		
3		
4		
...		

Санал асуулга эхэлсэн хугацаа

Санал асуулга дуусгавар болсон хугацаа

Баг/хорооны Засаг даргын гарын үсэг:

Баг/хорооны Иргэдийн нийтийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх төслийн саналын урьдчилсан жагсаалт

Д/д	Төслийн санал	Саналын төрөл	Санал өгсөн буюу саналыг дэмжсэн иргэдийн тоо	Төсвийн тухай хууль, энэ журамд заасан зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэлд багтах эсэх	Нийт санал өгөх баг/хорооны сонгуулийн насны иргэдийн тоо	Төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэгдэх асуудал	Үр өгөөж хүртэгчдийн тоо	Төслийн нийт төсөвт өртөг (урьдчилсан байдлаар) /мян.төг/
1.								
2.								
3.								
...								

Баг/хорооны Засаг даргын гарын үсэг:/ /
20... оны ...сарын ... өдөр

6 дугаар хавсралт

БАГ/ХОРООНЫ ИНХ-ЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Энэхүү маяг т.ыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал авах

- Баг/хорооны ИНХ-ын хуралдааны ирц, огноо
- Баг/хорооны ИНХ-ын хуралдаанаар иргэдээс гарсан саналыг хэлэлцэж, санал хураалт явуулсан хураангуй тэмдэглэлийг тамга, тэмдэгээр ба талгаажуулан сум/дүүргийн ЗДТГ-т тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аймаг/Нийслэл
Сум/Дүүрэг

Баг/Хороо

Байршил
Эхэлсэн цаг/мин
Дууссан цаг/мин

Хуралдааны хүчин төгөлдөр ирц:

Хуралдааны зорилго:

II. ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ: (ИНХ-ын хуралдааны ирцийн хүчин төгөлдөр байдлыг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу тооцно)

Баг/хорооны ерхийн тоо	Баг/хорооны хүн амын тоо	Хуралдаанд оролцох боломжтой насанд хүрсэн иргэдийн тоо	Үүнээс оролцсон иргэдийн тоо

III. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ ХУРААХ, ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Нийтийн байгууламж, байгаль хамгаалал, дэд бүтцийн чиглэлээр хэрэгжих төсөл, арга хэмжээний саналын жагсаалт

	Хэлэлцэгдсэн төслийн санал	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо
1.		
2.		
...		

Мал аж ахуй, бэлчээрийн эрсдэл, ХАА-н чиглэлээр хэрэгжих төсөл, арга хэмжээний саналын жагсаалт:

	Хэлэлцэгдсэн төслийн санал	Төслийн байршил	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо	Санал өгсөн иргэдийн тоог багийн сонгуулийн насны нийт хүн амын тоонд харьцуулсан харьцаа
1.				
2.				
...				

ТӨСЛИЙГ ЭРЭМБЭЛЭХЭД ХЭРЭГЛЭСЭН АРГУУДЫГ ТЭМДЭГЛЭНЭ ҮҮ.

☐ гар өргөх

□ бусад

IV. ХУРЛЫН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ТАЛААР (Иргэдийн нийтийн хурлаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр санал болгосон хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг сум, дүүргийн төсвийн төсөлд тусгах, сум, дүүргийн ИТХ-д өргөн барихтай холбоотой ажлыг зохион байгуулах үйл ажиллагааг дор дурьдаж, баталгаажуулах)

	Авах арга хэмжээнүүд	Хэн хариуцах	Товлосон хугацаа
1.			
2.			

Бусад зүйлс

Жич: Баг, хорооны ИНХ-ын үйл ажиллагаанд оролцсон иргэдийн нэрсийн жагсаал т-ыг Баг/хорооны ИНХ-ын даргын гарын үсгээр баталгаажуулсан байна.

Тэмдэглэл хөтөлсөн:..... /

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Баг, хорооны Засаг дарга/ИНХ-ын дарга: /

20... оны сарынөдөр

7 дугаар хавсралт

Баг/хорооны ИНХ-аар батлагдсан төслийн танилцуулга

(ОНХС-ийн хөрөнгө оруулалт)

(Бэлчээрийн мал аж ахуй)

1. Баг/хорооны нэр*			
2. Төслийн нэр*			
3. Баг/хорооны хувьд төслийн тэргүүлэх ач холбогдол*:	Баг/хорооны ИНХ-аар эрэмбэлсэн эрэмбэ		
	Баг/хорооны ИНХ-аас баталсан тэргүүлэх ач холбогдол бүхий нийт төслийн тоо		
4. Төслийг санал болгосон этгээд*:	Иргэн:..... Сум/ дүүргийн ЗДТГ-аас санал болгосон:		
5. Төслийн танилцуулга			
5.1 Төсөл хэрэгжүүлснээр шийдвэрлэгдэх асуудал*			
5.2 Төслийн товч танилцуулга	Зорилго:		
	Байршил: Төслийн үндсэн үйл ажиллагаа:		
5.3 Төслийн хамрах салбар* (Сум/дүүргийн тэргүүлэх чиглэлийн салбарт үндэслэх)	1)		
	2)		
	3)		
	4)		
	5)		
	Сум/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй хамааралгүй		
5.4 Үр өгөөж хүртэгчдийн тоо* (төслийн үр өгөөжийг хүртэгчид нь аймаг/нийслэл, сум/дүүргийн бодлого болон ядуурлын түвшин, алслагдмал байдал, жендер, ястан угсаатны онцлогоос хамаарна)	Үр өгөөж хүртэгчдийн тоо:		
	Үүнээс зорилтот бүлгийн иргэдийн тоо		
(Төвөөс алслагдсан нутаг дэвсгэрт амьдардаг малчин өрхийн гишүүд, амьжиргааны доод түвшнээс доогуур орлого той өрхийн гишүүд эсвэл үндэстний цөөнх иргэдийн тоо г.м.)			
5.5 Бусад мэдээлэл(хүчин чадал, техникийн үзүүлэлт гэх мэт)			
5.6 Төслийн шаардлагатай таамагт төсөвт өртөг (төгрөг)			
5.7 Төслийн жилийн үйл ажиллагааны болон ашиглалтын зардал (төгрөг)	Үйл ажиллагааны буюу ашиглалтын зардал гарах уу?	Тийм Үгүй	Таамаг дүн:
	Үйл ажиллагааг явуулах хүний нөөц шаардах уу?	Тийм Үгүй	Таамаг дүн:
	Үйл ажиллагаа, ашиглалтыг хариуцах этгээд	Нэр:.....	Нийт дүн: Зардлын эх үүсвэр:

5.8 Орон нутгийн иргэд болон хувийн хэвслээс санал болгож буй ОНХС-ийн нэмэлт санхүүжилт	Эх үүсвэр	
	Дүн төгрөг	
5.9 Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөлүүд	Газар чөлөөлөх/олгох*	Тийм Үгүй
	Техник, эдийн засгийн үндэслэл	Тийм Үгүй
	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагатай эсэх	Тийм Үгүй
	Бусад зөвшөөрөл шаардлагатай эсэх	Тийм Үгүй
	Боловсон хүчний орон тоог нэмэх шаардлагатай эсэх	Тийм Үгүй
	Бусад нөхцөлүүд -----	Тийм Үгүй
5.11 Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Эхлэх огноо:.....	
	Дуусах огноо:.....	
6. Журмын дагуу Төсвийн тухай хуульд заасан зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэлд багтах эсэх*	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэл	
	Зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэлд багтах эсэх нь тодорхой бус	
7. Боловсруулсан	Баг/хорооны Засаг дарга:	
	Гарын үсэг:	
	Огноо:	

*Мэдээллийг баг/хорооны Засаг дарга заавал бөглөнө.

8 дугаар хавсралт

.....аймаг/нийслэлийн,сум/дүүргийн "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт

(мянган төгрөг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	20..онд санхүүжих дүн
1.	Шилжих хөрөнгө оруулалт,хөтөлбөр төсөл арга хэмжээ	I			I=2+...3
	1.1 Төсөл арга хэмжээ 1	2			
	1.2 Төсөл арга хэмжээ 2	3			
2.	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	II			II=...4+...+6
	2.1 төсөл арга хэмжээ1	4			
	2.2 төсөл арга хэмжээ 2	5			
	2.3 төсөл арга хэмжээ 3	6			
3.	ОНХС-аас санхүүжих суурь зардал	III			III=7+8+9+...
	Үүнээс:				
	3.1 Хот тохижилтын гэрэлтүүлэг засвар үйлчилгээ	7			
	3.2 Мал эмнэлгийн үйлчилгээ	8			
	3.3 Усан хангамжийн татаас	9			
4.	Сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	IV			IV=10+...
5.	Сум/дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүн ^[2]	10			
6.	НИЙТ	11			11=I+II+IV

9 дүгээр хавсралт

..... Аймаг/нийслэлийн "Орон нутгийн хөгжлийн сан"-аас аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн "Орон нутгийн хөгжлийн сан"-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээ /төгрөг/

Д/д	Аймаг(нийслэл)-ийн ОНХС-аас сум (дүүрэг)-ийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн эх үүсвэрүүд		Дүн
1	Сум 1 /Дүүрэг1/	I.	I.=2+9+10+11+12

1.1	ОНХС-аас тооцсон суурь тооцооллын дүн:		
	1.1.4 Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	6.	
	1.1.5 МЕГА төслүүдээс бусад төслүүдийн АМНАТ	7.	
	1.1.6 Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	8.	
1.2	ОНХС-аас санхүүжих суурь зардал	9.	
1.3	Аймаг/нийслэлийн төсвөөс тухайн сумд олгох бусад нэмэлт эх үүсвэр	10.	
1.4	Өмнөх оны үлдэгдэл	11.	
1.5	Бусад	12.	
2	Сум 2 /Дүүрэг2/	II.	II.=2+9+10+11+12
2.1	ОНХС-аас тооцсон суурь тооцооллын дүн:	2.	2=3+...+8
	Үүнээс:		

	2.1.1 Олон улсын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэг	3.	
	2.1.2 ОНХС-ийн гүйцэтгэлийн урамшуулал	4.	
	2.1.3 Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	5.	
	2.1.4 Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	6.	
	2.1.5 МЕГА төслүүдээс бусад төслүүдийн АМНАТ	7.	
	2.1.6 Итгэлцүүрээр хуваарилагдсан хөрөнгө	8.	
2.2	ОНХС-аас санхүүжих суурь зардал	9.	
2.3	Аймаг/нийслэлийн төсвөөс тухайн сумд олгох бусад нэмэлт эх үүсвэр	10.	
2.4	Өмнөх оны үлдэгдэл	11.	
2.5	Бусад	12.	
Нийт сумдад хуваарилах ОНХС-ийн эх үүсвэр		III.	III.=I+...II
3	Аймаг/нийслэл/-ийн ОНХС	IV.	IV=1+...+7
3.1	Орон нутгийн төсөвт үлдэх хувь хэмжээгээр тооцсон дүн ²	1	
3.2	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	2	
3.3	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл	3	
3.4	МЕГА төслүүдээс бусад төслүүдийн АМНАТ	4	
3.5	ОНХС-аас санхүүжих суурь зардал	5	
3.6	Өмнөх оны үлдэгдэл	6	
3.7	Бусад	7	
ОНХС-ийн нийт хөрөнгө		V.	V=III+...IV
Нийт		...	V=III+...IV

² Энэ маягтын 3.1 дэх хүснэгтэд Төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн ОНХС-д үлдэх хувийг тооцож батална.

Сум/дүүргийн "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

дд	Төсөл, арга хэмжээний нэр	Хамаарах чиг үүргийн заалт	Он Батлагдсан төсөв Тодотгосон төсөв	ОНХС-аас санхүүжих суурь зардал	Бодит гүйцэтгэл /хөрөнгө оруулалтын ангиллаар/					
					Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Их засвар	Хөтөлбөр	Төсөл арга, хэмжээ	Нийт дүн
1	Хот тохижилт-гэрэлтүүлэг									
2	Мал эмнэлгийн үйлчилгээ									
3	Усан хангамжийн татаас									
....	Төсөл арга хэмжээ1									
.....										
	НИЙТ ДҮН									

Хянасан...../Сум/дүүргийн Засаг дарга/

Баталсан...../Сум/дүүргийн Санхүүгийн алба, Төрийн сангийн хэлтсийн дарга/

20... оны ...сарын ... өдөр

[1]58.1.8 Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх

58.1.12 Мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналтыг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх

58.2.11 Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх

58.2.12 Мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх

58.2.15 Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх том хэмжээний тохижилт, нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайл уулах ажлыг зохион байгуулах

58.3.4 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх

58.4.3 Сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх

58.4.4 Мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх, хортон шавжийн устгал, хяналт, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор хохирлыг арилгах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх

58.4.9 Усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх

58.4.10 Орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх

[2]Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүнг энд тусгана. Сум, дүүргийн хувьд энд бичилт хийхгүй бөгөөд сум/дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг энэхүү маягтад тусгаж батална.

Жич: Сангийн сайдын 244-р журамд тусгагдсан Аймгийн ИТХ-ын тогтоолын 3 дугаар хавсралт, сум, дүүргийн ИТХ-ын тогтоолын 2 дугаар хавсралтыг энэ маягтын дагуу өөрчлөн дагаж мөрдөнө.